



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/15

Хөхөө

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хуралдаанаар баталсан 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт 9070079 (регистрийн дугаар)-д төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд үнэ төлбөргүйгээр 4-р багийн нутаг дэвсгэр Бүрэг 1-1 тоот 4335 м² газрыг (3898323 нэгж талбарын дугаартай) 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг Сумын Газрын даамал (Г.Чулуунбаатар)-д зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ